



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/211

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Г.Энхбаяраас аймгийн Засаг даргад холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.5, 28.2.6, дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарт олгож өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг төлөөлж оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011020